

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2023/12

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.XII	2022.XII	2023.XI	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	46.5	35.2	46.5	-	-	-	6.9% ▲
Инфляц	хувь	7.9	13.2	8.6	0.4% ▲	-	7.9% ▲	7.9 нэгж хувиар ▲
Ажилгүйдлийн түвшин, 2023УЗ	хувь	5.2% 2023 оны УЗ	5.4% 2022 оны УЗ	5.2% 2023 оны УЗ	-	-0.6% ▼ нэгж хувиар	-	-0.2% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	763	-979	1947	-1184 ▼	-	-	1743 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3421.21	3431.29	3440.64	-19.43 ▼	-	-	-10.08 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	5932	3836	5435.6	496 ▲	-	-	2096 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	66.7	31.8	60.0	-16% ▼	-	-	2.1 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1524.8	1453.3	1393	8.9% ▲	-	-	-5% ▼
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	13%	13%	0%	-	0%	0%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.9	3.4	4.2	14% ▲	-	-	45% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	7.45%	9.12%	8.11%	-0.66 нэгж хувиар ▼	-	-	-1.67 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

Нүүрсний экспортын хэмжээ 66.7 сая тоннд хүрэв.	2023 оны эцсийн байдлаар Монгол Улс 66.7 сая тонн нүүрс экспортонд гаргаж түүхэн дээд хэмжээг тогтоов. 2023 онд 50 сая тонн төлөвлөж байснаас 33% буюу 16.7 сая тонн нүүрс илүү экспортлосон байна.
Гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрэв.	Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2023 оны эцсийн байдлаар 4.9 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь түүхэн дээд үзүүлэлт юм.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монголбанк бодлогын хүүгээ хэвээр үлдээв.	2023/12/14	Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13, 14-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.9 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна. 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод барааны бүлгийн үнэ 8.4 хувь, үйлчилгээний бүлгийн үнэ 9.4 хувь, хүнсний бүлгийн үнэ 12.4 хувь, хүнсний бус бүлгийн үнэ 7.2 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна. 2023 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 11.9 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 6.3 хувиар, барааны бүлгийн үнэ 8.0 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 7.6 хувиар тус тус өсжээ.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 12 дугаар сард 3421.21 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.08 төгрөгөөр, өмнөх сараас 19.43 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 14%, өнгөрсөн жилийн мөн үеэс 45%-иар өсөж, 4.9 тэрбум ам.долларт хүрэв.

#### Улсын төсөв



Татварын нийт орлого 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 21.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.0 (38.8%) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 2.0 (51.6%) их наяд төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1.8 (2.0 дахин) их наяд төгрөг, нийгмийн даатгалын орлого 904.6 (29.8%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 827.2 (21.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин онцгой албан татвар 57.8 (6.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2023 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 15.2 тэрбум ам.доллар, импорт 9.3 тэрбум ам.доллар болж, тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Экспорт 2023 онд өмнөх оноос 2.6 тэрбум ам.доллароор өсөхөд нүүрс 2.4 тэрбум ам.доллар, жоншны хүдэр ба баяжмал 161.9 сая ам.доллар, газрын тос 122.9 сая ам.доллар, лаазалсан махан бүтээгдэхүүн 122.1 сая ам.доллар, адууны мах 104.3 сая ам.доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

#### Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.  
**Эх сурвалж: Олон улсын валютын сан**
- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N<sup>0</sup>  
**Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>**

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 12-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 12-р сар 2023 он, Монголбанк](#)
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)